



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар A/185

Мандалговь

Хээлтэгч малыг ээмэгжүүлэлт,
бүртгэлжүүлэлтэнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А", Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, дахь заалт, Сайнцагаан сумын 2021 оны засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2.2.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Наран, Тэвш, Далай, Үйзэн багийн хонь, ямаа, үхрийн хээлтэгч малыг ээмэгжүүлж, дахин давтагдашгүй хувийн дугаараар тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Дашням

ХААТасгийн мэргэжилтэн

Гишүүд: Н.Баярсайхан

Наран багийн Засаг дарга

Ш.Батбаатар

Тэвш багийн Засаг дарга

Ж.Зоригбаатар

Далай багийн Засаг дарга

Б.Мижиддорж

Үйзэн багийн Засаг дарга

Б.Батбаяр

Жолооч

Хоёр. Ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн зохион байгуулж үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч /Х.Дашням/-д үүрэг болгосугай.

Гурав. Ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлын бэлтгэл ажлыг хангаж, малчдад мэдээлэл өгөх, бэлэн байдлыг хангуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

